ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Завхан аймгийн прокурорын газар-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/185/НА-СТА-ТШЗ

---

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
    2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
    2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
    2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
    2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
    2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8
    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан....13
    4.1 Ерөнхий зүйл ....13
    4.2 Материаллаг байдал ....14
    4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14
    4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
    4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
    4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16
5. Аудитын илрүүлэлт ....16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 87

танай ___ -ны № ___ -т

АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН
ДАРГА Ч.ДЭЛГЭРМАА-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын нөөц сангаас Улаанбаатар хотод зохион байгуулагдах "Прокурорын албаны өдөр" арга хэмжээ болон прокуроруудын ажиллах аюулгүй тухтай орчин бүрдүүлэх зорилгоор 10,000.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлжээ.

Аудитын гол асуудал

Аймгийн Прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй бөгөөд завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас хэргийн газрын үзлэг, шүүх хуралдаан болон бусад мөрдөн шалгах ажиллагаанд прокурорын аюулгүй байдлыг хангахад зориулж 201,200.0 мянган төгрөгийн "Toyota Ланд cruiser-300 GXR" автомашин нийлүүлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон

улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/*

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

| ДАНС | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **27587885.39** | **47047466.56** |
| **33** | **АВЛАГА** | 647245.39 | 0.00 |
| **335** | **Бусад авлага** | 647245.39 | 0.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 647245.39 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 26940640.00 | 47047466.56 |
| 354 | **Хангамжийн материал** | 26940640.00 | 47047466.56 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2179000.00 | 2620700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 17094295.00 | 1116700.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 4493345.00 | 3150673.56 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3174000.00 | 40159393.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1907845621.04** | **2027611670.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1907845621.04 | 2027611670.48 |
| 392 | **Биет хөрөнгө** | 1896358121.04 | 2016454170.48 |
| 39201 | Барилга, байгууламж | 1851811400.00 | 1851811400.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -105748047.40 | -151365095.08 |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 56093872.60 | 255000000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -37282934.99 | -57317222.11 |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 148239560.00 | 162699760.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -59714613.93 | -86395720.62 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 80283091.00 | 72770161.08 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37822773.24 | -31997679.77 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2000000.00 | 1000000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2000000.00 | -250000.02 |
| 39217 | Номын фонд | 498567.00 | 498567.00 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 11487500.00 | 11157500.00 |
| 39301 | Програм хангамж | 1320000.00 | 1320000.00 |
| 39302 | Хасагдуулга | -192500.00 | -522500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10360000.00 | 10360000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1935433506.43** | **2074659137.04** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **0.00** | **38022998.10** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 38022998.10 |
| 413 | **Өглөг** | 0.00 | 38022998.10 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 0.00 | 38022998.10 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **1935433506.43** | **2036636138.94** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1935433506.43 | 2036636138.94 |
| 511 | **Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан** | 178057638.75 | 178057638.75 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 178057638.75 | 178057638.75 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 1693554502.68 | 1795757135.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1693554502.68 | 1694554502.68 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 101202632.51 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 63821365.00 | 62821365.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **1935433506.43** | **2074659137.04** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/*

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **912690502.60** | **1611030415.64** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 14271002.60 | 236260115.64 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 14271002.60 | 236260115.64 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | 14271002.60 | 225161817.64 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | 0.00 | 11098298.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 898419500.00 | 1374770300.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 886919500.00 | 1350770300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 886919500.00 | 1350770300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11500000.00 | 24000000.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 11500000.00 | 24000000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **983167969.37** | **1508489690.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 983167969.37 | 1508489690.83 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 976081447.29 | 1393408666.98 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 609835623.81 | 968222165.79 |
| 210101 | Цалин | 321152275.69 | 550960305.88 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 176259960.72 | 264706007.49 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30427127.54 | 64418000.00 |
| 210104 | Урамшуулал | 81996259.86 | 88137852.42 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74500048.87 | 121538657.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 50638414.04 | 82807854.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5968694.77 | 9702500.58 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4774955.79 | 4841350.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1180590.44 | 4841350.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 11937393.83 | 19345601.18 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 62165484.29 | 72870302.99 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 11486054.29 | 13101802.99 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 46383500.00 | 54857110.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 4295930.00 | 4911390.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43236959.56 | 47314022.97 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 8737950.00 | 16782100.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 15854055.00 | 17787106.44 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 4956874.56 | 3991746.53 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 1199100.00 | 799800.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 12488980.00 | 7953270.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 33012410.00 | 12732300.00 |
| 210604 | Урсгал засвар | 33012410.00 | 12732300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17426600.00 | 9646400.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 17426600.00 | 9646400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | 13346116.00 | 24739242.03 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12974130.00 | 22990200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 0.00 | 1404000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128986.00 | 124042.03 |
| 210805 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | 44000.00 | 22000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 199000.00 | 199000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 122558204.76 | 136345575.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12099540.00 | 19440000.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 2460000.00 | 2100000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 107998664.76 | 114805575.90 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7086522.08 | 115081023.85 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3500000.00 | 5220000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3500000.00 | 5220000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3586522.08 | 109861023.85 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3586522.08 | 109861023.85 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **-70477466.77** | **102540724.81** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | 10083333.29 | 1338092.30 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 0.00 | 1338092.30 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 10083333.29 | 0.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | **-10083333.29** | **-1338092.30** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **-80560800.06** | **101202632.51** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/*

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **898419500.00** | **1374770300.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 898419500.00 | 1374770300.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 886919500.00 | 1350770300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 886919500.00 | 1350770300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11500000.00 | 24000000.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 11500000.00 | 24000000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **872120100.00** | **1364022400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 872120100.00 | 1364022400.00 |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 865033577.92 | 1248941376.15 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 609835623.81 | 945710159.02 |
| 210101 | Үндсэн цалин | 330680985.47 | 541275793.07 |
| 210102 | Нэмэгдэл | 175170137.52 | 256071511.61 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30157190.85 | 63260674.49 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 73827309.97 | 85102179.85 |
| **2102** | **Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл** | 74500048.87 | 106027665.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 50692732.81 | 72246916.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 5965978.83 | 8460037.27 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 4764091.85 | 4223418.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 1167010.44 | 4223418.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 11910234.94 | 16873874.58 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | 62812729.68 | 72223057.60 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 12133299.68 | 12454557.60 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 46383500.00 | 54857110.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 4295930.00 | 4911390.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 49132109.56 | 45732351.53 |
| 210401 | Бичиг хэрэг | 10879450.00 | 17196400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20347400.00 | 15944435.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4956874.56 | 3991746.53 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1199100.00 | 799800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11749285.00 | 7799970.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22886610.00 | 17377100.00 |
| 210604 | Урсгал засвар | 22886610.00 | 17377100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 17426600.00 | 9646400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17426600.00 | 9646400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13617066.00 | 25099642.03 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 13245080.00 | 23350600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 1404000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128986.00 | 124042.03 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44000.00 | 22000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 199000.00 | 199000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14822790.00 | 27125000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12362790.00 | 25025000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2460000.00 | 2100000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7086522.08 | 115081023.85 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3500000.00 | 5220000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3500000.00 | 5220000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3586522.08 | 109861023.85 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3586522.08 | 109861023.85 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **26299400.00** | **10747900.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 26299400.00 | 10747900.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 26299400.00 | 10747900.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 26299400.00 | 10747900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 26299400.00 | 10747900.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-26299400.00** | **-10747900.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| **C01** | **2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **178,057,638.75** | **63,821,365.00** | **1,774,929,521.78** | | **2,016,808,525.53** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **178,057,638.75** | **63,821,365.00** | **1,774,929,521.78** | | **2,016,808,525.53** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | (80,560,800.06) | (80,560,800.06) |
| **C08** | **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **178,057,638.75** | **63,821,365.00** | **1,693,554,502.68** | **1,935,433,506.43** |
| **D01** | **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **178,057,638.75** | **63,821,365.00** | **1,693,554,502.68** | **1,935,433,506.43** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **178,057,638.75** | **63,821,365.00** | **1,694,554,502.68** | **1,936,433,506.43** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (1,000,000.00) | - | (1,000,000.00) |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 101,202,632.51 | 101,202,632.51 |
| **D09** | **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **178,057,638.75** | **62,821,365.00** | **1,795,757,135.19** | **2,036,636,138.94** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/*

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **886919500.00** | **883332977.92** | **1342274300.00** | **1228138176.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **886919500.00** | **883332977.92** | **1342274300.00** | **1228138176.15** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **873869500.00** | **870337897.92** | **1337054300.00** | **1228138176.15** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **610465400.00** | **609835623.81** | **1024671600.00** | **945710159.02** |
| 210101 | Үндсэн цалин | 329914000.00 | 325920352.74 | 570903000.00 | 541275793.07 |
| 210102 | Нэмэгдэл | 207475200.00 | 179930770.25 | 286558000.00 | 256071511.61 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 29256000.00 | 30157190.85 | 71065600.00 | 63260674.49 |
| 210104 | Урамшуулал | 43820200.00 | 73827309.97 | 96145000.00 | 85102179.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **75342500.00** | **74500048.87** | **128084000.00** | **106027665.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 52484900.00 | 50692732.81 | 87097100.00 | 72246916.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5714400.00 | 5965978.83 | 10246700.00 | 8460037.27 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 4571500.00 | 4764091.85 | 5123400.00 | 4223418.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1142900.00 | 1167010.44 | 5123400.00 | 4223418.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11428800.00 | 11910234.94 | 20493400.00 | 16873874.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **64293400.00** | **62812729.68** | **78816900.00** | **72223057.60** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 13277900.00 | 12133299.68 | 15486900.00 | 12454557.60 |
| 210302 | Түлш, халаалт | 46383500.00 | 46383500.00 | 58398000.00 | 54857110.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4632000.00 | 4295930.00 | 4932000.00 | 4911390.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **44726300.00** | **44724509.56** | **45072100.00** | **44232351.53** |
| 210401 | Бичиг хэрэг | 9900000.00 | 9879450.00 | 17200000.00 | 17196400.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 17198800.00 | 17179800.00 | 15944600.00 | 15944435.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 4827500.00 | 4956874.56 | 4827500.00 | 3991746.53 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1200000.00 | 1199100.00 | 800000.00 | 799800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 11600000.00 | 11509285.00 | 6300000.00 | 6299970.00 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **46688400.00** | **46686010.00** | **28125900.00** | **28125000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 16349400.00 | 16349400.00 | 3090000.00 | 3090000.00 |
| 210602 | Тавилга | 9950000.00 | 9950000.00 | 7657900.00 | 7657900.00 |
| 210604 | Урсгал засвар | 20389000.00 | 20386610.00 | 17378000.00 | 17377100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **17454800.00** | **17306600.00** | **8000000.00** | **7646400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 17454800.00 | 17306600.00 | 8000000.00 | 7646400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **379200.00** | **371986.00** | **2354200.00** | **2248542.03** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | | 500000.00 | 499500.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 0.00 | 0.00 | 1404000.00 | 1404000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 129000.00 | 128986.00 | 200000.00 | 124042.03 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44000.00 | 44000.00 | 44000.00 | 22000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 206200.00 | 199000.00 | 206200.00 | 199000.00 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14519500.00** | **14100390.00** | **21929600.00** | **21925000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11643500.00 | 11640390.00 | 19827600.00 | 19825000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2876000.00 | 2460000.00 | 2102000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3550000.00** | **3500000.00** | **5220000.00** | **5220000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3550000.00** | **3500000.00** | **5220000.00** | **5220000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 3550000.00 | 3500000.00 | 5220000.00 | 5220000.00 |
| | ХӨТӨЛБӨР 70703 | | | | |
| | АРГА ХЭМЖЭЭ 82315 | | | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **9500000.00** | **9495080.00** | **8496000.00** | **8151100.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9500000.00 | 9495080.00 | 8496000.00 | 8151100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **886919500.00** | **886919500.00** | **1350770300.00** | **1350770300.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **886919500.00** | **886919500.00** | **1350770300.00** | **1350770300.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 886919500.00 | 886919500.00 | 1350770300.00 | 1350770300.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **1.00** | **1.00** | **1.00** | **1.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **1.00** | **1.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **24.00** | **19.00** | **24.00** | **19.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 | 12.00 | 11.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 11.00 | 11.00 | 11.00 | 11.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайл

*2024 оны 12 дугаар сарын 31* *    /төгрөгөөр/*

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэттэл |
|---|---|---|---|
| | ХӨТӨЛБӨР 70703 | | |
| | АРГА ХЭМЖЭЭ 80101 | | |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **11000000.00** | **10400000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | 11000000.00 | 10400000.00 |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | 11000000.00 | 10400000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1500000.00 | 1500000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1500000.00 | 1500000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2600000.00 | 2000000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2600000.00 | 2000000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | 1700000.00 | 1700000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1700000.00 | 1700000.00 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5200000.00 | 5200000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5200000.00 | 5200000.00 |
| | ХӨТӨЛБӨР 70703 | | |
| | АРГА ХЭМЖЭЭ 82315 | | |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **13000000.00** | **13000000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | 13000000.00 | 13000000.00 |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | 13000000.00 | 13000000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | 13000000.00 | 13000000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13000000.00 | 13000000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **24000000.00** | **24000000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 24000000.00 | 24000000.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 24000000.00 | 24000000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Завхан аймгийн прокурорын газрын зорилго:**

Прокурорын байгууллага нь прокурорын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, баталгаа, прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, бие даасан байдлыг ханган ажилладаг хуулийн байгууллага. Тус байгууллагын эрхэм зорилго нь хараат бус, шударга, алагчлалгүй, үр нөлөө, бүтээмжтэй мэргэжлийн үйл ажиллагааг явуулахад оршино.

**Завхан аймгийн прокурорын газрын зорилт:**

Прокурорын байгууллага нь 2023-2026 онд олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх, прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах, прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох, хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах, цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийн нэмэгдүүлэх зорилттой ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн прокурорын газрын захиргааны үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Төрийн албаны тухай хууль
2. Прокурорын тухай хууль
3. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Төрийн хэмнэлтийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус газар нь дот оод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр

тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн прокурорын газар 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл болон мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Завхан аймгийн прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 139,225.63 мянган төгрөгөөр буюу 7.19 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 647.25 | - | -647.25 |
| Бараа материал | 26,940.64 | 47,047.47 | 20,106.83 |
| Үндсэн хөрөнгө | 1,907,845.62 | 2,027,611.67 | 119,766.05 |
| **Нийт хөрөнгө** | **1,935,433.51** | **2,074,659.14** | **139,225.63** |
| Богино хугацаат өр төлбөр | - | 38,023.00 | 38,023.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,935,433.51 | 2,036,636.14 | 101,202.63 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,935,433.51** | **2,074,659.14** | **139,225.63** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд: Үндсэн хөрөнгө:** Улсын ерөнхий прокурорын "Хөрөнгийг бүртгэлд авах тухай" 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/84 тоот тушаалаар 201,200.00 мянган төгрөгийн үнэ бүхий Ланд крузер LC300 GRX маркийн автомашин, 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/116 тоот тушаалаар 12,663.20 мянган төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг компьютер, 1,368.00 мянган төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг тог баригч, 2024 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/165 тоот тушаалаар 1,576.92 мянган төгрөгийн үнэ бүхий хүндрүүлэгчтэй сейфийг тус тус бүртгэлд авч, санхүүгийн тайланд тусган ажилласан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 301 дүгээр тогтоолоор үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоосон 1,000.00 мянган төгрөгийн гэр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 745 дугаар тогтоолоор үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоосон 7,353.70 мянган төгрөгийн 45 ширхэг тавилга эд хогшил болон компьютер тоног төхөөрөмжийн бүртгэлд тусгасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны А-1/997 дугаартай албан бичгийн дагуу УЕПрокурорын 2024.06.14-ний өдрийн А/105 тоот "Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" тушаалаар 2,298.87 мянган төгрөгийн Тоёота Прадо маркийн автомашиныг шилжүүлэн, санхүүгийн тайланд тусган ажилласан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 760 дугаар тогтоолоор 8,378.19 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг актлан, данснаас хасаж төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайланг хүргүүлэн ажилласан.

Завхан аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурорын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/16 тоот тушаалаар 3,090.00 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 7,657.90 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг худалдан авч, санхүүгийн тайланд тусган ажилласан.

**Бараа материал:** 2024 оны эхэнд 26,940.64 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 102,137.20 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр 11,098.30 мянган төгрөгийн бараа шилжүүлэн авч, 93,128.67 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгон 47,047.47 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үлдэж өмнөх оноос бусад хангамжийн материал өссөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 178,057.64 мянган төгрөг нь тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 750,702.90 мянган төгрөг, нийт зарлагыг 741,702.90 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 109,861.2 мянган төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,264,909.28 мянган төгрөг буюу 92 хувьтай байна. Энэ нь цалин 101,017.78 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,593.84 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| | **Сангийн яам** | | | | |
| **70703** | **Прокурорын хяналт** | **1,374,770.30** | **1,374,770.30** | **0.00** | **100%** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,361,054.30 | 1,251,538.18 | **109,516.12** | **92%** |
| 80802 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал | 5,220.00 | 5,220.00 | **0.00** | **100%** |
| 82315 | Байцаан шийтгэх ажиллагаа | 8,496.00 | 8,151.10 | **344.90** | **96%** |
| **НИЙТ** | | **1,374,770.30** | **1,264,909.28** | **109,861.02** | **92%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 23,400.00 мянган төгрөг зарцуулан ажилласан. Үүнээс: бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс 1,500.00 мянган төгрөг, дотоод албан томилолт 2,000.00 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,700.00 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 18,200.00 төгрөг тус тус зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Үнийн харьцуулалтын арга /Авзага хайрхан стар/ | Менежер ширээ, шүүгээ, сандал | 7,657.90 | 7,657.90 |
| 2 | Үнийн харьцуулалтын арга /Эйч ви эй си шигтгээ/ | Агаар цэвэршүүлэгч кондишн | 3,090.00 | 3,090.00 |
| **ДҮН** | | | **10,747.90** | **10,747.90** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн прокурорын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Үндраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн прокурорын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/74 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,611.030.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 32,220,6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 25,776.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүй тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн 1,611.030.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 32,220,6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 25,776.4 мянган төгрөгөөр тогтоосон.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн прокурорын газар 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж Батлагдсан төсвөөс үрэлгэн зардал гаргаж хивс 400.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь , Батлагдсан төсвөөс үрэлгэн зардал гаргаж , чихрийн сав 45.0 мянган төррөгөөр, нэг наст цэцгийн үр 20 уутыг авч 450.0 мянган төгрөгөөр худалдан авч нөөцөлсөн алдаанд зөвлөмж хүргүүлэн оны эцэст хэрэгжилтийг хүргүүлэн ирүүлсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд зөвлөмж

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | | | | | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 895.0 мянган төгрөгийн алдаа илэрч залруулан хэрэгжилтийг ирүүлсэн.

***Залруулсан алдаа:***

Завхан аймгийн прокурорын газар 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж Батлагдсан төсвөөс үрэлгэн зардал гаргаж хивс 400.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь , Батлагдсан төсвөөс үрэлгэн зардал гаргаж , чихрийн сав 45.0 мянган төррөгөөр, нэг наст цэцгийн үр 20 уутыг авч 450.0 мянган төгрөгөөр худалдан авч нөөцөлсөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-р" нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалт, ЗГ-ын 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн байдал:** залруулж тайлан гаргасан

**5.1 Төлбөрийн акт: тогтоогдоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

### 5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Санхүүгийн аудитаар алдаа  илрээгүй  тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Батлагдсан төсвөөс үрэлгэн зардал гаргаж хивс 400.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь , Батлагдсан төсвөөс үрэлгэн зардал гаргаж , чихрийн сав 45.0 мянган төррөгөөр, нэг наст цэцгийн үр 20 уутыг авч 450.0 мянган төгрөгөөр худалдан авч нөөцөлсөн | 1 | 895,0 | | | | | 1 | 895,0 | | | | |
| ДҮН | 1 | 895,0 | | | | | 1 | 895,0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-14

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2025-02-14